

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газар-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/60/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай хот

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 70463612 Цахим хаяг: batundraa@audit.gov.mn

Ахлах аудитор : Б.Дагвасүрэн

Утас:99014227 Цахим хаяг:dagvasurenb@audit.gov.mn

Аудитор П.Ганцолмон

Утас:70157405 Цахим хаяг:ulistaivanaudit@ubaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.	Аудитын санал дүгнэлт	2
2.	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	
2.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2	Аудит хийсэн үр дүнгийн тайлан	5
2.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3.	Аудитын тайлан	
3.1	Ерөнхий зүйл	12
3.2	Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3	Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4	Материаллаг байдал	13
3.5	Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7	Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8	Аудитын гол асуудал	14
3.9	Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал, Шилэн дансны хуулийн хэрэгжилт, бусад хууль тогтоомж	14
3.10	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11	Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4.	Аудитын илрүүлэлт	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. Төрийн аудитын санал, дүгнэлт


**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗРЫН ДАРГА Д.БАТМЭНД-д

№ 1702/20
тантай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

Боловруулсан
Д.Бат-Ундраа

Боловруулсан
Хүндэтгэл
Огноо: 2022.02.24

Хүлээн

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,139,165.24	110,125.79
33	АВЛАГА	2,139,165.24	80,125.79
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	115,465.00	-
335	Бусад авлага	2,023,700.24	80,125.79
3351	Байгууллагаас авах авлага	2,023,700.24	80,125.79
35	БАРАА МАТЕРИАЛ	-	30,000.00
354	Хангамжийн материал	-	30,000.00
35420	Аж ахуйн материал	-	30,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,177,087,578.66	1,167,884,453.82
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,177,087,578.66	1,167,884,453.82
392	Бнет хөрөнгө	1,177,087,578.66	1,167,884,453.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,200,000,000.00	1,200,000,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(30,000,000.06)	(45,000,000.09)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	68,000,000.00	19,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(68,000,000.00)	(12,999,999.84)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	20,356,000.00	23,001,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16,291,833.50)	(18,551,208.43)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,817,500.00	12,817,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,794,087.78)	(10,945,837.82)
39217	Ном	-	63,000.00
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(770,000.00)	(770,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I-II	1,179,226,743.90	1,167,994,579.61
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	177,624.00	44,334.19
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	177,624.00	44,334.19
413	Өглөг	177,624.00	44,334.19
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	177,624.00	44,334.19
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,179,049,119.90	1,167,950,245.42
51	Засгийн газрын хувь оролцоо	1,179,049,119.90	1,167,950,245.42
512	Хуримтлагдсан үр дүн	1,179,049,119.90	1,167,950,245.42
51210	Өмнөх үеийн үр дүн	1,179,049,119.90	1,179,049,119.90
51220	Тайлант үеийн үр дүн	-	(11,098,874.48)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,179,226,743.90	1,167,994,579.61

2.2 Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	271,411,460.00	245,903,430.16
12	ТАТВАРЫН БҮС ОРЛОГО	7,078,610.00	14,460,200.16
120	Нийтлэг татварын бүс орлого	7,078,610.00	14,460,200.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,078,610.00	14,460,200.16
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,078,610.00	5,510,200.00
1200045	Үнэ төлбөргүй хулээн авсан орлого	-	8,950,000.16
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	264,332,850.00	231,443,230.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	99,539,550.00	69,724,830.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,112,500.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон	86,427,050.00	69,724,830.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	164,793,300.00	161,718,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	164,793,300.00	161,718,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	292,518,363.25	257,002,304.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	292,518,363.25	257,002,304.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	216,389,850.40	207,462,009.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	120,065,426.15	129,010,736.00
210101	Үндсэн цалин	101,049,218.00	100,603,446.00
210102	Нэмэгдэл	19,016,208.15	28,407,290.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,536,015.41	18,786,660.64
210201	Тэтгэврийн даатгал	14,023,615.41	13,459,567.38
210202	Тэтгэмжийн даатгал	1,628,100.00	1,392,150.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,302,500.00	1,113,661.93
210204	Ажилгүйдлийн даатгал	325,600.00	256,443.98
210205	Эрүүл мэндийн даатгал	3,256,200.00	2,564,837.26
2104	Хавгамж, бараа материалын зардал	8,391,312.00	7,472,888.00
210401	Бичиг хэрэг	2,089,600.00	1,740,300.00
210402	Тээвэр, шатахуун	2,598,212.00	2,822,788.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,703,500.00	2,909,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,355,000.00	6,352,900.00
210604	Урсгал засвар	2,355,000.00	6,352,900.00
2107	Томшилт, зочны зардал	2,456,500.00	1,256,500.00
210702	Дотоод албан томшилт	2,456,500.00	1,256,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,316,280.00	718,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	378,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	221,280.00	221,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	93,000.00	96,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,269,316.84	43,863,525.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,870,900.00	25,452,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,398,416.84	18,411,125.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,128,512.85	49,540,295.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	68,742,260.00	49,424,830.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	68,742,260.00	49,424,830.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,386,252.85	115,465.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,386,252.85	115,465.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(21,106,903.25)	(11,098,874.48)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(21,106,903.25)	(11,098,874.48)

2.3 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,162,933,241.66	1,162,933,241.66
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,162,933,241.66	1,162,933,241.66
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	16,115,878.24	16,115,878.24
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,179,049,119.90	1,179,049,119.90
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,179,049,119.90	1,179,049,119.90
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,179,049,119.90	1,179,049,119.90
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(11,098,874.48)	(11,098,874.48)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,167,950,245.42	1,167,950,245.42

2.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	271,411,460.00	237,068,895.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,078,610.00	5,625,665.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,078,610.00	5,625,665.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,078,610.00	5,625,665.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,078,610.00	5,625,665.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	264,332,850.00	231,443,230.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	99,539,550.00	69,724,830.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,гүүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,112,500.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	86,427,050.00	69,724,830.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	164,793,300.00	161,718,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	164,793,300.00	161,718,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	271,411,460.00	236,780,895.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	271,411,460.00	236,780,895.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	195,282,947.15	187,240,600.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	120,801,167.15	128,169,900.00
210101	Үндсэн цалин	101,784,959.00	100,146,510.00
210102	Нэмэгдэл	19,016,208.15	28,023,390.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,979,500.00	17,929,500.00
210201	Тэтгэврийн даатгал	15,467,100.00	12,617,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,628,100.00	1,328,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,302,500.00	1,062,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	325,600.00	265,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,256,200.00	2,656,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,503,600.00	7,360,600.00
210401	Бичиг хэрэг	2,089,600.00	1,740,300.00
210402	Тээвэр, шатахуун	2,710,500.00	2,710,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,703,500.00	2,909,800.00
2106	Эл хогшил, урсгал засварын зардал	2,355,000.00	6,352,900.00
210604	Урсгал засвар	2,355,000.00	6,352,900.00
2107	Томилолт, зочны зардал	2,456,500.00	1,256,500.00
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	2,456,500.00	1,256,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,316,280.00	718,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	378,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	221,280.00	221,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	93,000.00	96,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,870,900.00	25,452,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,870,900.00	25,452,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,128,512.85	49,540,295.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	68,742,260.00	49,424,830.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	68,742,260.00	49,424,830.00

Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газар-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийтөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,386,252.85	115,465.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,386,252.85	115,465.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	288,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	288,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	288,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	288,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	288,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(288,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдний засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	166,718,400.00	167,228,600.00	(510,200.00)	100%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	166,718,400.00	167,228,600.00	(510,200.00)	100%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	166,718,400.00	167,228,600.00	(510,200.00)	100%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	132,812,100.00	128,169,900.00	4,642,200.00	97%
210101	Үндсэн цалин	113,637,700.00	100,146,510.00	13,491,190.00	88%
210102	Нэмэгдэл	19,174,400.00	28,023,390.00	(8,848,990.00)	146%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,929,500.00	17,929,500.00	-	100%
210201	Тэтгэврийн даатгал	12,617,100.00	12,617,100.00	-	100%
210202	Тэтгэмжийн даатгал	1,328,100.00	1,328,100.00	-	100%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,062,500.00	1,062,500.00	-	100%
210204	Ажилгүйдлийн даатгал	265,600.00	265,600.00	-	100%
210205	Эрүүл мэндийн даатгал	2,656,200.00	2,656,200.00	-	100%
2104	Хангамж, бараа материалын зардал	7,648,600.00	7,648,600.00	-	100%
210401	Бичиг хэрэг	2,089,600.00	2,028,300.00	61,300.00	97%
210402	Тээвэр, шатахуун	2,710,500.00	2,710,500.00	-	100%
210403	Шүүдэн, холбоо, интернэтийн төлбөр	2,848,500.00	2,909,800.00	(61,300.00)	102%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,352,900.00	6,352,900.00	-	100%
210604	Урсгал засвар	6,352,900.00	6,352,900.00	-	100%
2107	Томилголт, зочны зардал	1,256,500.00	1,256,500.00	-	100%
210702	Дотоод албан томилголт	1,256,500.00	1,256,500.00	-	100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	718,800.00	718,800.00	-	100%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	378,700.00	378,700.00	-	100%
210803	Даатгалын үйлчилгээ	221,800.00	221,800.00	-	100%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	96,300.00	96,300.00	-	100%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	-	100%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,152,400.00	(5,152,400.00)	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,152,400.00	(5,152,400.00)	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	166,718,400.00	167,344,065.00	(625,665.00)	100%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	161,718,400.00	161,718,400.00	-	100%
132001	Орон нутгийн төсвөөс	161,718,400.00	161,718,400.00	-	100%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,000,000.00	5,625,665.00	(625,665.00)	113%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	5,625,665.00	(625,665.00)	113%

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газар-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газартай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улиастай ван аудит ХХК-ийн ахлах аудитор П.Ганцолмон, аудитор Д.Гэрэлхүү нар гүйцэтгэж, ахлах аудитор Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 17-ны өдрийн 01/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газар нь Засаг даргын дэргэдэх орон нутгийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэгч байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газар нь Дотоод аудитын нэгж байхгүй.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай байна гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны эхний хагас жилийн нийт орлого 161,768.4 мянган төгрөгийн 1 хувиар буюу 1,617.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,132.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлого 245,903.4 мянган төгрөгийн 1 хувь буюу 2,459.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг түүний 70 хувь буюу 1,721.3 мянган төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	2,139.2	80.1	-2,059.1
Бараа	-	30.0	30.0
Үндсэн хөрөнгө	1,177,087.5	1,167,884.4	-9,203.1
Нийт хөрөнгө	1,179,226.7	1,167,994.5	-11,232.2
Өр төлбөр	177.6	44.3	-133.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,179,049.1	1,167,950.2	-11,098.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө	1,179,226.7	1,167,994.5	-11,232.2

Авлага дансны үлдэгдэл 2,059.1 мянган төгрөгөөр буурсан нь авлагын үлдэгдлийг барагдуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 23,781.1 мянган төгрөг болж өссөн нь тайлант онд хандив тусламжаар ОБЕГ-ын харьяа 185-р ангиас УАЗ хантер маркийн авто машиныг 45,000.0 мянган төгрөгөөр, иргэн Н.Төрмөнхөөс Зил 130 авто машиныг 8,390.0 мянган төгрөгөөр авч, 24,858.6 мянган төгрөгийн хуучин барилгыг данснаас хассан зэрэгтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9,203.1 мянган төгрөгөөр буурсан нь аймгийн Засаг даргын Тамгын газарт Toyota Land Criuser 200 маркийн 68,000.0 сая төгрөгийн өртөгтэй тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлсэнтэй хобоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 11,098.9 мянган төгрөг болж буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 166,718.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж батлуулсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 161,718.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, 5,625.7 мянган төгрөгийн өөрийн орлого бүрдүүлэн, урсгал үйл ажиллагаанд 167,228.6 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 115.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 69,724.8 мянган төгрөгийн өмч борлуулсаны орлогыг төвлөрүүлэн, уг орлогын 30 хувь 15,500.0 мянган төгрөгийг аймгийн ИТХуралд, 4,800.0 мянган төгрөгийг Их-уул сумын ЗДТГ-д, 49,424.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тохируулга тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Орон нутгийн өмчийн газар нь Аймгийн Засаг даргын албан тоотыг үндэслэн 4,800.0 мянган төгрөгийг Их-Уул сумын ЗДТГ-т шилжүүлсэн нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ыг зөрчсөн байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 148 мэдээллээс 143 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон мэдээлэл 4, 2020 оны санхүүгийн аудитын тайлан, зөвлөмжийг шилэн дансанд огт оруулаагүй байна.

Байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд тус байгууллагад санхүүгийн тайлангаар итгэл үзүүлсэн тул зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар зарлага гаргахыг таслан зогсоох, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9,613.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс зориулалт бусаар зарцуулсан 4,800.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 4,813.1 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа илрээгүй.

4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Албан шаардлага:

- ✓ Илрүүлэлт: Аймгийн Засаг даргын албан тоотыг үндэслэн 4,800.0 мянган төгрөгийг Их-Уул сумын ЗДТГ-т шилжүүлсэн нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ыг зөрчсөн байна.
- ✓ Өгсөн албан шаардлага: Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ыг шинэчлэн батлуулж, мөрдөх

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

- ✓ Илрүүлэлт: Тус байгууллага нь тайлант хугацаанд 38,251.5 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн боловч татварын сайт дахь и баримтын бүртгэлээр 33,438.3 мянган төгрөгийн худалдан авалтыг тайлагнаж, 4,813.1 мянган төгрөгийн гүйлгээг и баримтгүйгээр бүртгэж тайланд тусгасан байна.
- ✓ Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ."; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ."; гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орон нутгийн өмчийн газар	2	9.6	-	-	-	-	1	4.8	1	4.8